



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/97

Мөрөн сум

Мэргэжлийн зөвлөл байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг мэргэжлийн шаардлага, стандартад нийцүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, үйлдвэрлэлийн сургалт, дадлагыг чанаржуулах зорилгоор мэргэжлийн байгууллага, холбоод, ажил олгогчид, инженер-техникийн ажилтнууд бүхий "Мэргэжлийн зөвлөл"-ийг нэгдүгээр, тус зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Мэргэжлийн зөвлөлүүдийг удирдлагаар хангаж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нягт уялдуулж, төгсөгчдийг ажлын байраар хангаж, нийгмийн түншлэлийг өргөжүүлэн хөгжүүлж ажиллахыг Мэргэжлийн зөвлөлийн дарга нарт даалгасугай

3. Мэргэжлийн зөвлөлүүдийн ажлыг уялдуулж, мэргэжлийн үнэлээчдийг бэлтгэж, сургалт, дадлагын ажлын явцын болон төгсөлтийн үнэлгээг чанартай зохион байгуулж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн захирал (Н.Баатар-Очир)-д үүрэг болгосугай

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН